

**ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
12 ДУГААР САРЫН ТОВЧ МЭДЭЭЛЭЛ**

Нэг: Нутгийн удирдлага зохион байгуулалтын талаар: Аймгийн Засаг даргын зөвлөлийн хурал 1 удаа хуралдаж 2 асуудал хэлэлцэж, 1 асуудлыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт, 1 асуудлыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд уламжлав.

Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлүүлэх тухай хуулийн хүрээнд аймгийн Засаг даргад 13 өргөдөл бичгээр хүлээн авч, 10 өргөдлийг шийдвэрлэж, 3 өргөдөл шийдвэрлэгдэх шатандаа, аймгийн Засаг даргын Тамгын газарт 4 өргөдөл бичгээр хүлээн авч, 2 өргөдлийг шийдвэрлэж, 2 өргөдөл шийдвэрлэгдэх шатандаа, аймгийн Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлд 6 өргөдөл хүлээн авч 4 өргөдлийн хариу өгч шийдвэрлэн 2 өргөдөл шийдвэрлэгдэх шатандаа тус тус хүлээгдэж байна.

Иргэдээс 7 сувгаар мэдээлэл хүлээн авах 7043-1111 төвд 2 сувгаар 25 мэдээлэл хүлээн авахад дуудлагаар 23, биечлэн 2 иргэн санал, гомдол ирүүлснээс гомдол 12, санал хүсэлт 12, талархал 1 тус тус бүртгэж холбогдох хэлтэс тасгийн дарга нарт шилжүүлж, 22 иргэний санал хүсэлт, гомдолд хариу өгч шийдвэрлэн шийдвэрлэлт 88,0 хувьтай байна.

Иргэдээс Монгол улсын Их хурал, түүний өргөдлийн байнгын хороонд хандан гаргасан өргөдлийг “Саналын хайрцгаар өргөдөл хүлээн авах журам”-ын дагуу тайлант сард санал хүсэлтийн хайрцагт ирсэн өргөдөл бүртгэгдээгүй болно.

Засгийн газрын 1111 төвд ирсэн 12 санал хүсэлт хүлээн авч холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, хариуг илгээв.

Хоёр: Эдийн засаг, төсөв санхүүгийн хүрээнд: Орон нутгийн төсвийн байгууллагуудын 12 дугаар сард улсын төсвөөс авах санхүүжилт бүрэн ирж, санхүүжилтийг батлагдсан хуваарийн дагуу олгож, цалин хөлс, тогтмол зардал, орон нутгийн хөгжлийн сан зэрэг зардлуудыг хянаж санхүүжүүлээ.

Орон нутгийн төсвийн 2018 оны төслийг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлэн, хурлаас гарсан санал хүсэлтийг тусгаж батлууллаа.

Сум, байгууллагуудад 2017 оны төсвийн төлөвлөгөөг аймгийн Засаг даргын 2017 оны 1/2889, 1/2890 тоот албан бичгээр хүргүүлж, сумдын төсвийн төлөвлөгөөг хүлээн авч, төсвийн программд нэгтгэв. Улсын төсвөөс орон нутагт авах 2017 оны

санхүүгийн дэмжлэг, орлогын болон тусгай зориулалтын шилжүүлгийн хуваарилалтын саналыг нэгтгэн Сангийн яаманд хүргүүлэв.

Аймгийн Засаг даргын албан даалгаварын хэрэгжилтийг хангах зорилгоор төсвийн өр, авлага бууруулах, төсвийн зарим орлого өндөр төсөвлөгдсөнөөс тасарсан, зарлагыг санхүүжүүлэх эх үүсвэр дутагдсан санхүүгийн өр үүсгэсэн сум, байгууллагуудад 29726,7 мянган төгрөг, боловсролын салбарын байгууллагуудад 67708,8 мянган төгрөг, боловсролын салбарын багц дотор нь 107,0 сая төгрөг, төсвийн шууд захирагчдын батлагдсан төсвийн зардал хооронд зохицуулалт хийх шийдвэрийн дагуу аймгийн төвийн зарим байгууллага болон 8 сумын төсөвт байгууллагад 75119,4 мянган төгрөг, эрүүл мэндийн байгууллагуудад 9,9 сая төгрөг, тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагад 10,4 сая төгрөгийн зохицуулалт хийгдэв.

Сум, байгууллагуудын санхүүч, нягтлан бодогч нарыг ажлын үзүүлэлтээр шалгаруулж Сангийн яамны шагналаар 3, аймгийн шагналаар 4 ажилтныг шагнаж урамшуулан санхүүгийн байгууллагад олон жил үр бүтээлтэй ажилласан 28 ахмадад хүндэтгэл үзүүллээ.

Хөрөнгө оруулалтын гүйлгээ хийх бүрд өмнөх санхүүжилтийн тооцоо, захиалагчийн хяналтын зардал, магадлашгүй ажлын гүйцэтгэл, зураг төсвийн тооцоо, хугацааны алданги зэрэг тооцооллуудыг хянаж тойрох хуудас бүрэн зурагдаж, төлбөрийн мэдэгдэл гарсан үед гүйцэтгэгч байгууллагад төлбөрийг шилжүүлэн ажиллав.

Төсөвт байгууллагын нэмэлт дансны орлогын зарцуулах эрхийг заавар, журмын дагуу хянаж, холбогдох баримт бичиг бүрдүүлэн удирдлагад тухай бүр танилцуулсны дараа Сангийн яаманд шуурхай санал хүргүүлж, улсын болон орон нутгийн төсвийн 81 байгууллагын 1,3 тэрбум төгрөгийн нэмэлт дансны зарцуулах эрхийг нээлгэн зарцуулах эрх нээсэн зардлын эх үүсвэрийг прийбаланс програмд хөтөлбөр зориулалт бүрээр орлогоос хуваарилах бичилтийг хийж гүйцэтгэв.

Аймгийн Татварын хэлтэс нь НӨАТ-ийн 285 тайлан хүлээн авч, виз хүссэн 3, зээл авах 17, зөвшөөрөл сунгах 1, тендерт оролцох 4, бусад 5 лавлагаа тодорхойлолтыг 30 татвар төлөгчдөд олгов.

Төрийн сангийн цахим сайтаар татварын орлогын хуулгыг нэр төрөл бүрээр авч мэдээллийн санд боловсруулалт хийлээ. Мөн 17 татвар төлөгчтэй холбоотой 10 төрлийн татварын 18.7 сая төгрөгийг залруулах бичилт хийв. Хөндлөнгийн мэдээлэл

цуглуулах, мэдээллийн эх үүсвэрийг татварын хяналт шалгалтын үйл ажиллагаанд ашиглаж нэгдсэн сан бүрдүүлснээр 16 хамаарагчтай 8 агуулагчтай татвар төлөгчийн 38 ширхэг 127.9 сая төгрөгийн хөндлөнгийн мэдээллүүдийг цуглуулав.

Улс, аймаг, сум орон нутгийн төсөвт нийт 11769.2 сая төгрөг орж төлөвлөгөө 902,6 сая төгрөг буюу 8,9 хувиар давсан байна. Үүнээс улсын төсөвт 2239.2 сая төгрөг орж төлөвлөгөө 433,6 сая төгрөгөөр буюу 24 хувиар, аймгийн төсөвт 7599.6 сая төгрөг орж төлөвлөгөө 100 хувиар, сумын төсөвт 1933.6 сая төгрөг төлөвлөгөө 471,7 сая төгрөг буюу 20 хувиар тус тус давж биелсэн урьдчилсан гүйцэтгэлтэй байна.

Тайлант сард 13 аж ахуйн нэгж байгууллагыг татварын хяналт шалгалтанд хамруулж, татвар төлөгчдөд гаалийн болон хөндлөнгийн мэдээллийг ашиглан шалгалт хийж 772.9 сая төгрөгийн зөрчилд 60.3 сая төгрөгийн нөхөн татвар ногдуулж, хуулийн дагуу 17.9 сая төгрөгийн торгууль, 24.4 сая төгрөгийн алданги, нийт 102.8 сая төгрөгийн нөхөн татвар торгууль, алданги ногдуулж ажиллалаа.

Ажиллах хүчний судалгааг Жаргалант сумын Наран, Дарви сумын Дэлгэр, Ховд сумын Улаанбураа багуудад, Өрхийн нийгэм эдийн засгийн судалгааг Жаргалант сумын Рашаант, Үенч сумын Жаргалан гол, Зэрэг сумын Гүвээ багуудын нийт 62 өрхөд хийж, судалгааны материалаа хянан шалгаж шивэлт хийхээр бэлтгээд байна.

Үндэсний статистикийн хороо, Биеийн тамир спортын газрын хамтарсан биеийн тамир, спортын улсын нэг удаагийн үзлэг, тооллогын ажлыг 11 дүгээр сарын 27-ны өдрөөс 12 дугаар сарын 20-ны өдрүүдэд хийж, тооллогын дүн мэдээг хянан нэгтгэж байна.

Аймгийн Засаг даргын захирамжаар мал тооллого зохион байгуулах, хяналт тавих комисс байгуулагдаж, аймгийн хэмжээнд 6 ажлын хэсэг томилогдон ажиллав. Мал тооллогын урьдчилсан дүнгээр 3448.9 мянган толгой мал тоолуулсаны дотор тэмээ 25660, адуу 132153, үхэр 200590, хонь 1324322, ямаа 1766267 толгой мал тус тус тоологдов. Хамгийн олон мал тоолуулсан сумдаар Манхан 298.8, Мянгад 263.9, Булган 258.5, Чандмань 254.7 мянган толгой мал тоолуулж бусад сумдаас тэргүүлж байна. 2017 оны эцэст Дарви /4,1/, Манхан /1,6/, Чандмань /25,8/, Эрдэнэбүрэн /4,6/, Жаргалант /0,8/ мянган толгойгоор буурч, бусад 12 сум малаа дүнгээрээ өсгөсөн дүнтэй байна.

Гурав: Хууль эрх зүйн салбарын хүрээнд: Хэлтсийн хурлыг 3 удаа хийж, 12 иргэнд хууль зүйн зөвлөгөө өгч, 1 иргэнд анхан шатны бичиг баримт боловсруулж тусламж үзүүлэв. Шинээр албан тушаалд томилогдсон 5 албан тушаалтны ХАСХОМ-

ийг хүлээн авч, 2 албан тушаалтны ХАСУМ-ийг Авлигатай тэмцэх газарт хянуулж цахим болон цаасан бүртгэл хийв. Архивын лавлагаа, магадлагаагаар 21 иргэнд үйлчилж, 2 хөмрөгийн 16 хадгаламжийн нэгж, 2009-2007, 1976-1982 оны 3120 хуудас баримтыг бүртгэлийн хамт цахим хэлбэрт оруулав.

Цагдаагийн газар: Тайлант сард иргэд олон нийтийг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, тэдний хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, олон нийт цагдаагийн хамтын ажиллагааг сайжруулах, аливаа урьдчилан сэргийлэх ажилд төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийг өргөнөөр татан оролцуулах зорилгоор дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

Гэр бүлийн хүчирхийлэл, архидан согтуурах явдлаас урьдчилан сэргийлэх, эцэг эх, үр хүүхэд, гэр бүлээ хайрлан хамгаалах чиглэлээр 10 төрлийн богино хэмжээний шторк бэлтгэн орон нутгийн 2 телевиз, цахим сүлжээгээр олон нийтэд хүргэсэн.

Хууль сурталчлах ажлын хүрээнд Хүний эрхийн үндэсний комиссын аймгийн төлөөлөгчтэй хамтран Хөгжимт драмын театрын 23 уран бүтээлчид, Политехник коллежийн 62 багш, ажилчид, ерөнхий боловсролын 1, 7 дугаар сургууль, Алтай, Манхан сумдын ахлах ангийн 321 сурагчдад "Хулгайн гэмт хэргийн тухай ойлголт", "Хүний эрх, үүрэг", "Гэр бүлийн хүчирхийллээс сэргийлэх нь", "Насанд хүрээгүй хүүхдээс үйлдэгдэж байгаа гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан нөхцөл, түүнээс сэргийлэх нь", "Компьютер, гар утасны хор хөнөөл" сэдэвт сургалтыг зохион байгууллаа.

"Тайван амгалан Ховдчууд" хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах зорилгоор баривчлагдсан, эрүүлжүүлэгдсэн хүмүүс болон архины хамааралтай 25 иргэнд "Хорт зуршлаас сэргийлье" сургалтыг аймгийн ЗДТГ-ын Хууль эрх зүйн хэлтэс, Эрүүл мэндийн газар, Улаан загалмайн хороотой хамтран, сумдын олон нийтийн цагдаа нарыг чадавхижуулах сургалтыг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Олон нийттэй харилцах алба, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн санхүүжилтээр зохион байгуулав.

"Хөршийн холбоо" байгуулах сургалт хэлэлцүүлгийг Ховд Гэр бүлийн радио 104.0, аймгийн Засаг даргын Тамгын газар, Жаргалант сумын Засаг даргын Тамгын газар, Хүний эрхийн үндэсний комиссын Ховд аймаг дахь салбартай хамтран зохион байгууллаа.

Буянт, Эрдэнэбүрэн, Ховд, Дуут сумдын нутаг дэвсгэрт цагдаагийн алба хаагчид "Морин эргүүл"-ээр ажиллаж, иргэдээс 9 мэдээлэл хүлээн авч, 4 гэмт хэргийг

илрүүлэн шалгаж байгаа ба малын хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 162 иргэнд яриа таниулга хийлээ.

“Тамхины хяналт шалгалт” хэсэгчилсэн арга хэмжээний үеэр зөвшөөрлийн бус цэгт худалдаалж байсан 145 ширхэг тамхи хураан авч, зөрчил бүхий 13 хүнийг 550.000 төгрөгөөр торгох арга хэмжээ авав. Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, зам тээврийн осол эндэгдлээс бага насны хүүхдийг урьдчилан сэргийлэх зорилгоор 12 жилийн 1 дүгээр дунд сургуулийн багш, ажилчдад яриа таниулга, зөвлөгөө өгч, сургуулийн ойролцоох замын 2 гарцанд шинээр “Сургууль орчмын бүс” замын тэмдэг байрлуулж, хамгаалалтын бүс хэрэглэж хэвших, зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх талаар шторк бэлтгэн олон нийтэд хүргэж ажиллав.

Аймгийн хэмжээнд тайлант сард нийт 24 гэмт хэрэг бүртгэгдсэн ба, гэмт хэргийг төрлөөр нь ангилан үзвэл: хулгайлах 7, мал хулгайлах гэмт хэрэг 5, хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 3, хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх 4, хүчиндэх 1, хөрөнгө завших 1, авто тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих гэмт хэрэг 3, хууль бусаар ашигт малтмал хайх, олборлох 1, авлигын гэмт хэрэг 1, бусдын эд хөрөнгийг залилан мэхэлж авах гэмт хэрэг 1, төрийн албан тушаалтан албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулах гэмт хэрэг 1 тус тус бүртгэгдсэн байна.

Иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас 273 гомдол мэдээлэл хүлээн авч, 34 буюу 12,4 хувийг гэмт хэргийн, 239 буюу 87,5 хувийг захиргааны зөрчлийн талаарх гомдол мэдээлэл эзэлж байна. Зөрчил гаргасан нийт 144 хүнийг албадан саатуулж, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон, гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн, жижгээр танхайрсан зөрчилд 26 хүнийг 7-30 хоногийн хугацаатайгаар баривчилж, 46 жолоочийн тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг хасч, зөрчил гаргасан 98 хүнийг 8,460,000 төгрөгөөр торгох арга хэмжээ авав.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар – 457 дугаар нээлттэй, хаалттай хорих анги: Алба хаагчдын ажлын хариуцлага, сахилга батыг дээшлүүлэх, цэрэгжилч, жагсаалч байдлыг хангах, ажлын цаг ашиглалт, ажил үйлчилгээний чанарыг дээшлүүлэх зорилгоор ажил эхлэх, дуусах цагуудад ажилчдыг нэгтгэн бүртгэж, ажлын цаг ашиглалтанд хяналт тавьж ажиллахын зэрэгцээ 7 хоногийн Баасан гарагт нийт бүрэлдэхүүнд хичээл, сургалт, мэдээлэл хийж, жагсаалын бэлтгэл, хувцасны үзлэгт хамруулан, илэрсэн зөрчил дутагдлыг тухай бүр арилгуулав. “Нэг цонхны үйлчилгээ

бүхий албан контор, Цагдан хорих байр"-ны барилгын ажил бүрэн дуусаж, улсын комисст хүлээн авав.

Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд Цагдаагийн газартай хамтран ажиллах гэрээний дагуу хуваарьт өдрүүдэд 2 алба хаагчийг эргүүлийн үүрэг гүйцэтгэгчээр ажиллуулав.

Хорих ангийн харуул хамгаалалтыг "Хорих ангийн харуул хамгаалалтын журам"-ын дагуу зохион байгуулж, ангийн даргын тушаалаар онцгой учралын үед ажиллах төлөвлөгөөг шинэчлэн батлуулж, алба хаагчдад танилцуулан өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна. Мөн шуурхай бүлгийн алба хаагчдыг томилон, эргэн шалгах төлөвлөгөөний дагуу тус ангийн тасаг нэгжүүд шөнийн болон өдрийн цагаар харуул хамгаалалтын үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагчдын ажлыг хянан ажиллав.

Болзошгүй ажиллагааны үед ашиглагдах Тээврийн хэрэгслийн бэлэн байдал, гал унтраах багаж хэрэгсэл, нөөц цахилгаан үүсгүүр, гар чийдэн, гэрлийн шил, бэлэн байдлын түлшний талон зэргийг тогтмол шалган бүртгэлээр хүлээлцэн алба хаагчдад өдөр бүр бичгээр үүрэг даалгавар өгч биелэлтэнд хяналт тавив.

Шүүхийн шинжилгээний алба: Шүүхийн шинжилгээний албанд хандаж 14 албан бичиг, 84 шинжилгээ хийлгүүлэх тогтоол, захирамж ирүүлснийг хүлээн авч, байгууллагаас 33 албан бичиг боловсруулан холбогдох байгууллагад хүргүүлэв.

Шүүх эмнэлгийн бүтцийн шинжилгээг 3 цогцост, гэмтлийн зэрэг тогтоох үзлэгийг 19 хүнд, бэлгийн холбогдолтой 1, химийн шинжилгээ 4, биологийн шинжилгээ 4, криминалистикийн шинжилгээ 10 тус тус хийж, нийт 41 дүгнэлт гарган алсын дуудлаганд 1 удаа явсан ба ДНК-ийн санг 8, сумны хонгио 86, хошуу 86 ширхэгээр баяжуулсан.

Гэмт хэргийн газрын үзлэгт 17 удаа оролцож, хэргийн газрын үзлэгээр гутлын мөр 7, тээврийн хэрэгслийн мөр 5, бусад ул мөр, эд мөрийн баримт 20 илрүүлж бэхжүүлэн, гарын хээний дардас 163 тус тус авч АДИС-Папилон салбар станцад баяжилт хийв. Криминалистикийн шинжээч нар гэрэл зургийн ажил 264 хийснээс шинжилгээний 29, хэргийн газрын үзлэгийг 109, цогцосны үзлэг задлан шинжилгээний 70, бусад 56 тус тус хийж, цагдаагийн байгууллагад хүргүүлэв.

Албанаас гаргасан гэмтлийн зэрэг тогтоох шинжилгээ, бүтцийн болон химийн, биологийн, криминалистикийн шинжилгээнүүдийн дүгнэлтийг тухай бүрт нь цахимжуулав.

Төлбөрт үйлчилгээний орлогод 5.646.000 төгрөг төвлөрүүлэв.

Улсын бүртгэлийн хэлтэс: Тайлант сард иргэний бүртгэлийн чиглэлээр 2186, аймгийн хэмжээнд шилжих хөдөлгөөнд 618 иргэн хамрагдаж, шилжин ирсэн 65, шилжин явсан 21 иргэн, аймаг доторх сумаас суманд, багаас багт шилжсэн 532, гадаад паспорт олголт, сунгалтыг 195 иргэнд, иргэний үнэмлэх 285 иргэнд шинээр олгож, 249 иргэнд сунгалт хийж, дахин олгосон 110, иргэний бүртгэлийн лавлагаа 306 иргэнд олгож, иргэний гэр бүлийн байдлын 8 төрлийн үйлчилгээгээр нийт 2838 иргэнд үйлчлэв. Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн чиглэлээр 536, хуулийн этгээдийн бүртгэлийн чиглэлээр 103 иргэнд холбогдох үйлчилгээг үзүүлж ажиллав.

Иргэдээс нийт 13 өргөдөл, гомдол, санал хүсэлт ирснээс хуулийн хугацаанд 11 асуудлыг шийдвэрлэж, хугацаа болоогүй 2 өргөдөл шийдвэрлэлтийн шатандаа хүлээгдэж байна.

Дөрөв: Нийгмийн бодлого салбарын хүрээнд:

Боловсролын чиглэлээр: Багш ажилтны ажлын байран дахь эрэлт хэрэгцээнд үндэслэн мэдлэг, аргагүй ур чадварыг хөгжүүлэх зорилгоор “Онлайн сургалт зохион байгуулах чадавхыг хөгжүүлэх” сургалтыг 12 дугаар сарын 7-9-ний өдрүүдэд аймгийн Боловсрол, соёл урлагийн газар, Багшийн мэргэжил дээшлүүлэх институтийн цахим сургалтын албаны дарга, арга зүйч нар удирдан зохион байгууллаа. Сургалтад мэдээллийн технологийн 24 багш, Боловсрол, соёл урлагийн газрын дарга, мэргэжилтэн нийт 37 хүн хамрагдаж, мүүдл системийг ашиглан онлайн сургалтын агуулга хөгжүүлэх, сургалтын хөтөлбөр боловсруулах, үнэлгээний арга зүй, контентийг удирдах зэрэг арга зүйд суралцлаа.

Салбарын хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, сургалтын үйл ажиллагааны төлөвлөлт зохион байгуулалтыг сайжруулах, БСШУСЯ-ны бодлогыг сурталчлах, боловсрол, соёлын салбарт олон нийтийн оролцоог өргөжүүлэх зорилгоор 2017 оны 12 дугаар сарын 21-24-ны өдрүүдэд Чандмань, Дарви, Зэрэг, Манхан, Буянт сумдын цэцэрлэг, сургууль, соёлын байгууллагын үйл ажиллагаатай танилцаж, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэв. Хяналт үнэлгээ хийх, зөвлөн туслах ажлын хүрээнд 11 цагийн судлагдахуун, 3 цагийн сургалтын үйл ажиллагаанд ажиглалт хийж, сургалтын арга зүй, технологийг сайжруулах зөвлөмжийг өгч ажиллав. “Дотуур байр хүүхдийн хөгжлийн орчин” үндэсний зөвлөлгөөнд аймгийн 21 төлөөлөл оролцогч оролцож, дотуур байрны үйл ажиллагаанд тулгамдаж буй

асуудлыг бүлгийн хэлэлцүүлгээр гаргасан бөгөөд аймгийн үйл ажиллагааны сайн туршлага болон бүтээлийн үзэсгэлэнг оролцогчид өндрөөр үнэлэв.

Соёл, Спортын чиглэлээр: Байгууллагын үйл ажиллагааны 2017 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган Музейн захирлын А/18 дугаар тушаалаар байгууллагын эд хөрөнгийн, үзмэрийн, сан хөмрөгийн, үзүүлэгийн танхимын тооллого зохион байгуулах ажлын хэсэг томилогдон тайлант сард тооллогыг бүрэн дуусгав.

Музейн сан хөмрөгт урианхай угсаатны хөгжмийн зэмсэг болох товшуур хөгжим худалдан авч сан хөмрөгийг баяжуулахын зэрэгцээ МҮОНТВ-ийн алтан сан хөмрөгт аймгийн Музейн шилдэг үзмэрүүдийг хадгалах зураг авалт хийгдэв.

Аймгийн Биеийн тамир спортын газрын 2017 оны нэгдсэн арга хэмжээний төлөвлөгөөний дагуу дараах ажлуудыг хийж хэрэгжүүллээ. 2017 оны сургалт бэлтгэлийн хуваарийн дагуу спортын 10 төрлөөр 550 гаруй тамирчин сурагчид бэлтгэл сургуулилтад хамрагдаж, бэлтгэл 1-5 дахь өдрүүдэд өглөө, өдөр 2 ээлжээр хичээллэж байгаа бөгөөд бүс, улсын чанартай тэмцээнүүдэд бэлтгэгдэж байна.

Аймгийн Нийтийн номын сан 411 уншигчдад шинээр карт нээж, 5730 ирцэд 5714 ном, сонин хэвлэл олгож 430 ширхэг шинэ номоор фондын баяжилт хийгдэв. Мөн шинэ номын үзэсгэлэн, өдөрлөг, нээлттэй хаалганы өдөр зэрэг арга хэмжээг зохион байгуулж байгууллагын үйл ажиллагааг олон нийтэд сурталчлав. Мөн оны эцсийн ажлаа дүгнэн оны шилдгүүдээ тодруулж, шагнаж урамшуулав.

Эрүүл мэндийн чиглэлээр: Эрүүл мэндийн салбарын жилийн эцсийн ажлын үнэлгээг хийж дуусгах, улирлын чанартай ханиад томуугаас урьдчилан сэргийлэх, өвөлжилтийн хүндрэлтэй нөхцөлд зорилтот бүлгүүдийн иргэдийн эрүүл мэндийг хамгаалах, тайлан мэдээг нэгтгэж холбогдох газруудад хүргүүлэх ажлууд хийж гүйцэтгэлээ. Нийгмийн эрүүл мэндийг дэмжих ажлын хүрээнд Чандмань сумын эрүүл мэндийн төв, шүдний хувийн 4 эмнэлэг, Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтэстэй хамтран аймгийн төвд үйл ажиллагаа эрхэлдэг, эрүүл мэндийн даатгалын сангаас үнийн хөнгөлөлт үзүүлэхээр гэрээ байгуулсан 11 эмийн сан, 5 өрхийн эрүүл мэндийн төвүүдэд халдвар хамгаалал, халдваргүйтгэл, ариутгал, эрүүл мэндийн байгууллагын хог хаягдал зэрэг үйл ажиллагааг үнэлж, хяналт тавин ажиллаа

Эрүүл мэндийн яамнаас зохион байгуулагдсан “Хүний хөгжил амьдралын хэв маяг” үндэсний зөвлөгөөн, Осол гэмтлийн анхан шатны яаралтай тусламжийн сургагч багш бэлтгэх сургалтанд холбогдох мэргэжилтнүүдийг хамруулж, Норвегийн тусламжийн байгууллагын Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг

бэхжүүлэх II хөтөлбөрийн тайлангийн хурлыг зохион байгуулж, эрүүл мэндийн талаар дэвшүүлсэн зорилтын биелэлтийг нийт сум, өрх, Бүсийн оношилгоо эмчилгээний төв, Эрүүл мэндийн газрын мэргэжилтнүүд, хамтрагч байгууллагын төлөөллүүдийг оролцуулан зохион байгууллаа.

Тайлант сард дархлаажуулалтын хамрагдалт болон зарцуулалтын мэдээг анхан шатны нэгжүүдтэй тулгалт хийж, тайлангийн бэлтгэл ажлыг ханган, галзуугийн сэжигтэй мал амьтанд хазуулсан 1 тохиолдол бүртгэгдэж, вакцинжуулах арга хэмжээг авч, дархлаажуулалтын нэгжүүдэд шаардагдах томуугийн вакцин 260 х/т, тавт 300 х/т, А гепатитын вакцин 185 х/т, халдварт саагийн вакцин 620 х/т, сүрьеэгийн вакцин 760 х/т, В гепатитын вакцин 270 х/т, улаанбурхан, улаанууд, гахай хавдрын вакцин 350х/т, 5мл тариур 72 ширхэг, 0.5мл тариур 829 ширхэг, 0.05 мл тариур 300 х/т, тарилгын карт 200 ширхэгийг тус тус хуваарилан хүргүүллээ.

Халдварт өвчний, тандалт мэдээллийг сайжруулан өвчний сарын мэдээг сум, өрхийн эрүүл мэндийн төвүүд, Бүсийн оношилгоо эмчилгээ төвөөс авч, <http://103.17.109.29:1441/> цахим сайтад шивж бааз үүсгэв. Мөн томуу, томуу төст өвчний мэдээг 7 долоо хоног бүр 6 өрх, 16 сумын эрүүл мэндийн төв, Бүсийн оношилгоо эмчилгээний төвөөс авч нэгтгэн томуугийн үндэсний төвийн <http://fis.flu.mn/> цахим сайтад мэдээллийг байршуулав.

Аймгийн Бүсийн оношлогоо эмчилгээний төв, сумын нэгдсэн эмнэлэг, сум дундын эмнэлэг, сумдын эрүүл мэндийн төвүүдийн эмийн 2017 оны тендерт шалгарсан 15 компаний гэрээний биелэлтийг дүгнэж, 2018 оны хэрэгцээт эм, эмнэлгийн хэрэгсэл, лабораторын урвалж оношлуур худалдан авах тендерийг Сангийн яам болон Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын цахим сайтад байршуулан тендерийн урилгыг нийтлэн тендер шалгаруулалттай холбоотой тодруулга мэдээллийг компаниудад өгч ажиллав.

Тусгай зөвшөөрлийн комиссын хурлыг зохион байгуулж, БОЭТ, хувийн хэвшлийн 3 эмнэлэг, эмийн сангийн үйл ажиллагаа эрхлэх 2 тусгай зөвшөөрлийг сунгаж, 2 хувийн эмнэлгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгов. Мөн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацаагаа түр түдгэлзүүлсэн 6 хувийн хэвшлийн эмнэлгээс 3 эмнэлэгийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг сэргээсэн.

Өвөлжилт хүндэрч болзошгүйтэй холбогдуулан өвөлжилтийн бэлэн байдлын цаг үеийн мэдээллийг 14 хоног тутамд 16 сум, 6 өрхөөр гарган нэгтгэж, аймгийн

Онцгой байдлын газарт мэдээг тухай бүр хүргэж ажиллав. Өөр аймаг сумдад отроор өвөлжиж байгаа 3856 хүн байгаагаас нярай 5, 0-5 хүртэлх насны хүүхэд 634, 46 жирэмсэн эх, ХБИ 54, 65-с дээш насны 281 иргэн байгааг бүртгэлжүүлэв.

Эх хүүхдэд үзүүлэх тусламж үйлчилгээг сайжруулах зорилгоор Эрүүл мэндийн анхан шатны байгууллагад ажиллаж буй эх баригч бага эмч нарын мэдлэг ур чадварыг дээшлүүлэх, тэднийг ажлын байранд дагалдан сургах, улмаар харилцан суралцаж туршлага солилцох, нөхцөл боломжийг бүрдүүлэн, харъяа хүн амд үзүүлэх эх барих эмэгтэйчүүд, хүүхдийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэхэд онол, дадлага хосолсон сургалтыг зохион байгуулж чадавхижуулав.

Салбарын удирдах ажилтан, мэргэжилтнүүдийг хамруулсан “Эх, хүүхдийн тусламж үйлчилгээнд эмнэлгийн шатлал хооронд тулгамдаж буй асуудлууд, шийдвэрлэх арга замууд” сэдэвт хэлэлцүүлгийг зохион байгуулж, харилцан мэдээлэл солилцож цаашид анхаарах, шийдвэрлэх асуудлуудын талаар санал солилцов.

Эрүүл мэндийн салбарт 13120.1 сая төгрөгийн эх үүсвэрээр 12815.3 сая төгрөгийг зардалд зарцуулж, 306.5 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй байна. Энэ нь сумдын эрүүл мэндийн төвүүд сарын хуваарьт өөрчлөлт орсон зардал гараагүй, Эрүүл мэндийн даатгалын сангаас авах санхүүжилт сарын эцсээр гүйлгээ хийгээгүйтэй холбоотой өсч, одоогоор 226.3 сая төгрөгийн өглөгтэй байна.

Эрүүл мэндийн яамны хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа сумдын эмнэлгийн халаалтын тогооны засвар үйлчилгээ, мотоциклоор хангах албан тоотыг холбогдох газарт хүргүүлж, санхүүжилтийг аймгийн хөрөнгө оруулалтад төвлөрүүлж, байгууллагуудын 2017 оны төсвийн урьдчилсан гүйцэтгэл, өглөг, авлагын мэдээ авч Булган сумын нэгдсэн эмнэлэгт 52,0 сая төгрөг нэмэлт санхүүжилт авч 5 эрүүл мэндийн хэмнэгдсэн зардлыг гүйлгэж зарцуулахаар сарын хуваарьт өөрчлөлт оруулж төрийн сангийн Fiscal программд шивж өөрчилснөөр сумдын эмнэлэг өглөгөө барагдуулах нөхцөл бүрдлээ.

2017 оны 12 дугаар сарын байдлаар нийт 319700 үзлэг хийгдэж, үүнээс урьдчилан сэргийлэх үзлэг 67341, төрөлт 2026 тус тус бүртгэгдэж, эхийн эндэгдлийн тохиолдол 1 буюу 100 000 төрөлтөд 49.1, нялхсын эндэгдэл 35 тохиолдол буюу 1000 амьд төрөлтөд 17,1 промил, 0-5 хүртэл насны хүүхдийн эндэгдэл 45 тохиолдол буюу 1000 амьд төрөлтөнд 22 промил болж өнгөрсөн мөн оны үеэс эхийн эндэгдэл 41.5, нялхсын эндэгдэл 2.5, 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 2,4 промилээр тус тус буурсан үзүүлэлттэй байна.

Халдварт өвчин 475 тохиолдол буюу 1000 хүн амд 56,9 гарч, өмнөх оны мөн үеэс 67,1 продицемилээр буурсан байна. Нийт халдварт өвчний 43,5 хувийг бэлгийн замаар дамжих өвчин, 6.9 хувийг сүрьеэ, 18.6 хувийг салхин цэцэг өвчин тус тус эзэлж байна.

Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгааллын чиглэлээр: Нийгмийн халамжийн тухай хуулийн хүрээнд нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт, тусламжийг иргэдэд түргэн шуурхай хүргэн ажиллаж байна. Нийгмийн халамжид улсын төсвөөс нийт 1.843.000.000 /төгрөг/-ийн санхүүжилт авснаас: Алдарт эхийн одонд 1.230.0 мянган төгрөг, алдар цолтой ахмадын хөнгөлөлтөд 107.0 мянган төгрөг, ахмадын “Насны хишиг”-т 506.0 мянган төгрөгийн санхүүжилт тус тус зарцуулав.

Орон нутгийн төсвөөс 7,381,5 мянган төгрөгийн санхүүжилт авч, халамжийн тэтгэвэр 1733 иргэнд 2,534,8 мянган төгрөг, Нөхцөлт мөнгөн тэтгэмж 2098 иргэнд 1,242,3 мянган төгрөг, Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа шаардлагатай иргэнд үзүүлэх хөнгөлөлт, нөхцөлт мөнгөн тусламж 6902 иргэнд 598,243,1 мянган төгрөг, Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хуулийн дагуу олгогдож байгаа нэг удаагийн хөнгөлөлт , тусламж 6902 иргэнд 598,243,1 мянган төгрөг, Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгаалалын тухай хуулийн дагуу олгогдож байгаа хөнгөлөлт, тусламж 2514 иргэнд 288,546,0 мянган төгрөг, Жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй эхчүүдийн мөнгөн тэтгэмж 4048 иргэнд 1,009,581,3 мянган төгрөг, Алдарт эхийн одонтой эхчүүдэд олгосон тусламж 8807 иргэнд 1,206,520,0 мянган төгрөг, Алдар цолтой ахмадуудад үзүүлсэн хөнгөлөлт, тусламж 50 иргэнд 217,078,8 мянган төгрөг, Хүнс тэжээл нийгмийн хамгааллын хөтөлбөрт 1300 иргэнд 584,723,7 мянган төгрөг, Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ 336 иргэнд 19,670,0 мянган төгрөг, Насны хишиг 3092 иргэнд 505,980,0 мянган төгрөг нийт 30686 иргэнд 8,957,159,9 мянган төгрөгийг олгов.

Нийгмийн халамжийн тухай хуулийн хүрээнд үйлчилгээнд хамрагдах иргэдийн баримт бичгийг хянан хүлээн авч, нийгмийн халамж, үйлчилгээний мэдээллийн системд шивж, үйлчилгээг хуулийн хугацаанд шийдвэрлэн ажиллаж байна. 2017 онд аймгийн хэмжээнд шинээр 1350 хүүхэд мэндэлж 360-аад өрх дахин үнэлгээнд хамрагдан 1300 гаруй хүүхэд шинээр бүртгэгдэж хүүхдийн мөнгөнд хамрагдсан ба 0-18 насны 34000 гаруй хүүхэд хүүхдийн мөнгө авч байна.

2017 оны судалгаанд хамрагдаагүй, өрхийн амьжиргааны түвшингээ тодорхойлуулж хүүхдийн мөнгөнд хамрагдах хүсэлтэй 30 өрхийн өргөдөл хүлээн авч, ӨАТТС-аас хойш ирсэн өргөдлийн дагуу Жаргалант сумын 143 өрхийг ӨАТТС, дахин

үнэлгээнд хамруулан мэдээллийг ӨМНС-д шивж өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох боломжийг бүрдүүллээ. Шинээр төрсөн болон ӨМНС-д бүртгэлгүй байсан 45 хүүхдийн мэдээллийг бүртгэлээ.

Тайлант сард нийт 250 ажил идэвхитэй хайгч иргэнийг шинээр бүртгэж, 325 иргэний мэдээллийг шинэчлэн, бүртгэл мэдээллийн нэгдсэн санд идэвхижүүллээ. Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн LMIS программд бүртгэлтэй ажилгүй иргэд 1850 үүнээс эмэгтэй 923 иргэн байна. Ажил идэвхитэй хайгчдаас 1335 иргэнийг ажлын байранд зуучилсан ба шинээр гарсан 554 ажлын байрыг бүртгэж, бүртгэл мэдээллийн нэгдсэн LMIS санд шивж баталгаажуулав.

Ажил олгогч аж ахуй нэгж байгууллага иргэдээс 1444 ажлын байрны захиалга авч бүртгэлтэй ажил хайгч иргэдээс 1335 үүнээс эмэгтэй 660 иргэн ажилд зуучлагдан бБайнгын 823, улирлын 170, түр 342 ажлын байртай болсон байна.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газарт ажлын байрны захиалга ирүүлж хөдөлмөрийн зах зээлийн бүртгэл мэдээллийн нэгдсэн санд бүртгэлтэй ажил хайгч иргэнийг зуучлан ажлын байраар хангаж, шинэ ажлын байр бий болгосон, Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу ХБИ-г ажлын байраар хангасан, ажлын байранд Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн хууль дүрэм журмыг хэвшүүлэн ажилласан, улс орны эдийн засгийн хүндрэлтэй үед ажиллагсадынхаа ажлын байрыг хадгалан ажилгүйдэлд өртөхөөс хамгаалан ажиллаж байгаа аж ахуйн нэгж байгууллагуудыг шалгаруулан “Шилдэг ажил олгогч–2017” арга хэмжээг амжилттай зохион байгууллаа. Уг арга хэмжээнд 100 гаруй аж ахуй нэгж байгууллага, иргэн ажил олгогч нар оролцож, шилдэг захиалагч, зуучлуулагч байгууллага, шилдэг шинэ ажлын байр бий болгогч ажил олгогч, Хөдөлмөрийн аюулгүй байдлыг эрхэмлэгч байгууллага, Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажлын байраар хангасан шилдэг ажил олгогчийг тус тус шалгаруулж цом, өргөмжлөл, 500000 төгрөгөөр шагнаж урамшуулав.

Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох зөвлөгөө өгөх үйлчилгээнд нийт 1145 иргэд, үүнээс бүлгийн зөвлөгөө өгөх үйлчилгээнд 960, ганцаарчилсан зөвлөгөөнд 185 иргэн хамрагдав. Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бүлгийн сургалт үргэлжлэн 2 дугаар ээлжийн 10 ажил хайгч залуучуудын 1 дүгээр модуль сургалт зохион байгууллаа.

Хүүхэд, гэр бүлийн хөгжил, оролцооны чиглэлээр: Хүүхдийн эрх зөрчигдсэн 5 кейст нөхцөл байдлын үнэлгээ хийж холбон зуучлах үйлчилгээ

үзүүллээ. Хүүхдийн эсрэг хүчирхийллийг бууруулах “Нэгдүгээрт хүүхэд” 1 сарын аян өрнүүлж, 17 сумын 24 сургууль, аймгийн төвийн 53 аж ахуйн нэгж байгууллага, төрийн өмчит 4 цэцэрлэг, төрийн болон, төрийн бус, олон улсын байгууллагууд хүүхдийн төлөө нэгдэж, үйл ажиллагаагаа сурталчлан хамтран ажиллаа.

Тав: Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хүрээнд:

Байгаль орчны чиглэлээр: Аймгийн Засаг даргын 2017 оны өдрийн А/611 дугаар захирамжын дагуу “МоЭнКо” ХХК-ий Хөшөөтийн нүүрсний уурхайг ашиглах төслийн 2017 оны “Байгаль орчныг хамгаалах менежмент төлөвлөгөө”-ий хэрэгжилтийг дүгнэх зорилгоор 12 дугаар сарын 8-ны өдөр ажлын хэсэг Дарви сумын Хөшөөтийн нүүрсний уурхайд ажиллав. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга, мэргэжилтэн, Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга, мэргэжилтэн, Цаг уур, орчны шинжилгээний газрын дарга, Мэргэжлийн хяналтын газрын Байгаль орчны хяналтын улсын байцаагч, Цэцэг, Дарви сумын БОХУБайцаагч, байгаль хамгаалагч, Хөшөөт багийн Засаг дарга, иргэдийн төлөөлөл оролцлоо.

“МоЭнКо” ХХК-ний Байгаль орчны албанаас 2017 онд “Байгаль орчин хамгаалах менежмент төлөвлөгөө”-ий дагуу хийсэн ажлуудыг танилцуулж мэдээлэл өгсөн бөгөөд тайлантай дэлгэрэнгүй танилцлаа. Ажлын хэсгийн дүгнэлтээр тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний “Нүүлгэн шилжүүлэх нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө”, “Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт”, “Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь” гэсэн төлөвлөгөөний бүрэлдэхүүн хэсгийн биелэлт хангалтгүй байсан ба нийт 66 заалтаас 6 заалт тасарсан тул 2017 оны байгаль орчин хамгаалах менежмент төлөвлөгөөний биелэлтийг 84.14 хувьтай дүгнэлээ.

Цаашид тасарсан заалтыг хэрэгжүүлэхэд анхаарч ажиллах, 2018 оны төлөвлөгөөг боловсруулахдаа тодорхой хүрэх үр дүнтэй төлөвлөж, дүйцүүлэн хамгаалах, олон нийтийг мэдээллээр хангах арга хэмжээний талаар тодорхой ажил тусгах, амьтаны аймгийн судалгааг, тээвэрлэлт хийж буй авто замын засвар арчилгаанд анхаарч бодитой ажил төлөвлөж үр дүнд хүрч ажиллахыг зөвлөлөө.

“Бодонч нутгийн хишиг” нөхөрлөлийн Алтай сумын Тамт хэмээх газарт хууль бус ашигт малтмал олборлогчдын нөлөөлөлд өртөж эвдрэлд орсон 5га талбайд хийсэн нөхөн сэргээлтийн ажлыг хүлээж авах зорилгоор тухайн газартай танилцахад тус

газар нь уулын хавцал дагуу ургаа хад чулуу ихтэй, хүчин чадал багатай техник ашиглан нөхөн сэргээлтийг хийхэд хүндрэлтэй, зарим газарт техник тоног төхөөрөмж хүрэх боломжгүй, цаг агаар хүйтэрсэн зэрэг нөхцөл байдлын улмаас нөхөн сэргээлтийн ажил бүрэн хийгдээгүй тул цаашид анхаарах асуудлын талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өглөө.

Аймгийн Засаг даргын 2017 оны А/618 дугаар захирамжийн дагуу Дөргөн сумын Аргалант багийн нутаг “Хөх эргийн аараг” хэмээх газарт нөхөн сэргээлт хийх гэрээ байгуулсан “Блю гоулд” ХХК-ний үйл ажиллагаанд хяналт хийх, нөхцөл байдалтай газар дээр нь танилцах зорилгоор ажлын хэсэг байгуулагдан 12 дугаар сарын 18-ний өдөр ажиллалаа. Тус газартай танилцахад эвдэрсэн газрыг тойруулан хашаалсан бөгөөд нөхөн сэргээлтийн ажлыг 12 дугаар сарын 06-ны өдөр эхэлж ухагдсан шруф, нүх, тунелыг сэтлэх ажлыг хийж байсан боловч иргэдээс ирсэн гомдол, мэдээллийн дагуу 12 дугаар сарын 07-ны өдөр аймгийн Цагдаагийн газраас шалгалт хийж ашиглаж буй техник хэрэгсэл болон үйл ажиллагааг зогсоосоны улмаас нөхөн сэргээлтийн ажил хийгдээгүй байна. Мөн нөхөн сэргээлт хийх талбайгаас 1.5 км-ын зайд байх Чоно харайхын гол нөхөн сэргээлт хийж буй аж ахуйн нэгжийн буруутай үйл ажиллагааны улмаас бохирдож байна гэсэн мэдээллээр ажлын хэсэг газар дээр очиход нүдээр үзэхэд бохирдол ажиглагдаагүй бөгөөд уснаас дээж авч Мэргэжлийн хяналтын газрын лабораторит шинжлүүлэхэд бохирдолгүй гарсан болно.

2017 оны 12 дугаар сарын 5-8-ны өдрүүдэд БОАЖЯ-ны Аялал жуулчлалын бодлого зохицуулалтын газраас “Тогтвортой аялал жуулчлал”-ын талаар илтгэлүүд тавигдаж оролцогчдыг цаг үеийн мэдээлэл, арга зүйгээр хангаж ажиллав. Сургалтыг Дэлхийн аялал жуулчлалын байгууллагын зөвлөх, аялал жуулчлал, зочлох үйлчилгээний олон улсын эксперт, сургагч багш, судлаач Стэфэн Нөүкс удирдан явууллаа. Гурван өдөр үргэлжилсэн тус сургалт хоёр өдөр танхимын, нэг өдөр техникийн эрчимжүүлсэн хэлбэрээр явагдсан бөгөөд техникийн сургалтыг Улаанбаатар хот орчмын аялал жуулчлалын гол бүс болох Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газар зохион байгуулсан ба “Тогтвортой аялал жуулчлалын дэлхийн стандарт”, Тогтвортой менежмент, нийгэм эдийн засаг, соёлын болон хүрээлэн буй орчны нөлөө буюу нөөц баялгийн хэрэглээ, орчны бохирдлыг багасгах, биологийн төрөл зүйл, байгаль хамгаалал зэрэг шалгууруудад хэрхэн нөлөөлдөг талаар танилцууллаа.

Аймгийн Засаг даргын Тамгын газар, Уул уурхай хүнд үйлдвэрийн яам, Ашигт малтмал, газрын тосны газар, SESMIM төсөлтэй хамтран Монгол улсад уул уурхайн салбар үүсч хөгжсөний 75 жилийн ойн хүрээнд 11 дүгээр сарын 27-28-ны өдрүүдэд Ховд аймагт “Баруун бүсийн уул уурхайн чуулга уулзалт”-ыг зохион байгуулж Увс, Завхан, Говь-Алтай, Баян-Өлгий аймгийн төлөөллүүд оролцлоо. Чуулга уулзалтын зорилго нь эрдэс баялагт суурилсан хөгжлийн загвар, чиг хандлага, ойлголтыг бэхжүүлэх, төрөөс баримталж буй бодлого, хөтөлбөрийг танилцуулж, оролцогч талуудыг мэдээллээр хангах, бүс нутаг эрдэс баялагийн салбарт тулгуурлан хөгжих боломжийг тодорхойлох, удирдлага зохион байгуулалтын чадавхийг бэхжүүлэх, бодлогын хэлэлцүүлэг, санал зөвлөмж гаргах байлаа. Тус чуулга уулзалтын хүрээнд холбогдох газруудаас уул уурхайн салбарын өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудал, цаашдын чиг хандлага, баримтлаж буй бодлого, хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар мэдээлэл өгч, оролцогчдын саналыг авч тусган зөвлөмж боловсруулав.

УИХ-ын дэргэдэх Өргөдлийн байнгын хорооноос 2016 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 05 дугаар “Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай” тогтоолын дагуу хэрэгжүүлсэн арга хэмжээ, цаашид уул уурхай болон ашигт малтмалын улмаас эвдэрч сүйдсэн талбайг нөхөн сэргээх, арга хэмжээ авч ажиллах талаар 21 аймгийн удирдлагууд, холбогдох мэргэжилтнүүдтэй цахим хурал хийлээ. Уг хурлаар нөхөн сэргээлт нэрийн дор ашигт малтмал олборлох үйл ажиллагааг таслан зогсоох, бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журмыг боловсронгуй болгох, хяналтыг сайжруулах, хэрэгжилтийг эрчимжүүлэх чиглэлээр ярилцсан. Үүнтэй холбоотой УИХ, Засгийн газраас гарч буй аливаа тогтоол шийдвэрийн биелэлтүүдийг хэрэгжүүлж ажиллах талаар үүрэг чиглэл өглөө.

Хүнс, хөдөө аж ахуйн чиглэлээр: Өвөлжилт, хаваржилтыг өнтэй давах үүсч болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх зорилгоор аймгийн Засаг даргын Тамгын газраас санаачлан “Малчиддаа тусалъя” сайн санааны аянд нэгдсэн төрийн байгууллагууд хандив тусламж хүлээлгэн өгч, хандив хүлээлгэн өгсөн байгууллагуудын жагсаалт гаргаж орон нутгийн телевиз, цахим сайт, интернет сүлжээгээр олон нийтэд мэдээлж байна.

Аймгийн Засаг даргын А/606 дугаар захирамжаар мал тооллогын ажлыг аймгийн хэмжээнд зохион байгуулах ажлын хэсэг томилогдон 2017 оны 12 дугаар сарын 07-12-ны өдрүүдэд 10 хоногийн хугацаанд ажиллав. 2017 оны жилийн эцсийн

мал тооллогын урьдчилсан дүнгээр 3 448 192 толгой мал тоологдсон ба үүнээс адуу 132 074, үхэр 200 567, тэмээ 25 542, хонь 1 323 992, ямаа 1 766 017 толгой мал тоологдож мал таван төрөлдөө өссөн үзүүлэлттэй байна.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын зөвлөлийн хурлаар Дарви суманд үржүүлж буй Сутай омгийн хонийг үүлдрээр батлууллаа. Сутай хонь үүлдрээр батлагдаснаараа манай аймаг анхны хонины үүлдэртэй болж байна. Мянгад суманд үржүүлж буй Мянгад адууг омгоор баталгаажуулахад хянан магадлагаа хийх ажлын хэсэг намрын хянан магадлагаа хийж 7 хоног ажиллав. Тус ажлын хэсэг энэ удаагийн хяналтаар Мянгад адууны амьдын жин, биеийн хэмжээ, махны дээж болон бусад судалгаа, мэдээлэл авав.

Монгол улсад үржүүлж буй үүлдэр, омгийн малын үржил селекцийн ажлыг сайжруулах зорилгоор Алтайн улаан үүлдрийн ямааны үржлийн ажлын хөтөлбөр, төлөвлөгөөг УМЭҮГ-ын даргын дэргэдэх Мал үржлийн салбарын орон тооны бус зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж батлууллаа.

Улсын аварга малчин, тариаланч, хошой аварга, саальчин шалгаруулах ажлын хүрээнд сумдаас ирүүлсэн тодорхойлолт бусад бичиг баримтуудыг хянан аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхээр бэлтгэж байна
Аймгийн Засаг даргын 2017 оны А/573 дугаар захирамжаар төл малыг мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтад бүрэн хамруулж ажиллах ажлын хэсэг томилогдон 841,0 мянган толгой төл малыг вакцинжуулалтанд хамруулахаар төлөвлөн 753,2 толгой төл малыг вакцинжуулж, хамрагдалт 89 хувийн гүйцэтгэлтэй байна.

Мал эмнэлэг ариун цэврийн шинжилгээнд аймгийн хүнсний зах болон түүхий эдийн захад худалдаалагдаж буй 40200 кг мах махан бүтээгдэхүүний 2804 дээж, 22590 кг сүү сүүн бүтээгдэхүүний 1015 дээж, 1963 ш арьс шир, 5830 кг ноолуур, 2800 гогцоо өлөн гэдэс, 820ш өндөгний дээжид эмнэл зүй, чанар, аюулгүй байдлын шинжилгээ хийж, 106 кг сүү сүүн бүтээгдэхүүн шинжилгээгээр стандартын шаардлага хангаагүй нь тогтоогдож худалдаалахыг хориглосон шийдвэр гаргав.

Хан-орд ХХК-ий хүнсний зах, Түмэн цагаан шувуут тахианы аж ахуй, ОБГ-ын дэргэдэх Улсын нөөцийн салбар газар зэрэг аж ахуйн нэгж, байгууллагуудтай хамтран ажиллах гэрээ байгуулж, 12310 м² талбайд ариутгал халдваргүйжүүлэлт хийж, мал эмнэлэг ариун цэврийн үзлэг шинжилгээ, ариутгал халдваргүйжүүлэлтийн үйлчилгээнд 3,0 сая төгрөгийн орлого төвлөрүүллээ.

Авто замын чиглэлээр: Замын сангийн хөрөнгөөр Жаргалант суманд баригдах 10 км хатуу хучилттай авто замын инженерийн нарийвчилсан зураг төслийг, Ховд – Чандмань сум чиглэлийн 62 км авто замын ТЭЗҮ боловсруулах ажлыг бүрэн дуусгав.

Зургаа: Хяналт, шалгалт, үнэлгээ дотоод аудитын талаар: Засгийн газрын 2016 оны 121 дүгээр тогтоолоор батлагдсан 2016-2020 онд шинээр боловсруулах болон үргэлжлүүлэн хэрэгжүүлэх үндэсний хөтөлбөрүүдийн жагсаалтын дагуу Ховд аймагт холбогдолтой хэрэгжүүлэх УИХ-ын тогтоолоор батлагдсан 7, Засгийн газрын тогтоолоор батлагдсан 32, нийт 39 үндэсний хөтөлбөрийн биелэлтийг хэлтэс, сум, байгууллагуудаас гаргуулан авч нэгтгэн, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, холбогдох яамдад хүргүүлэхээр ажиллаж байна.

Монгол улсын Засгийн газрын тогтоол шийдвэрийн биелэлтийг холбогдох хэлтэс, сум, байгууллагуудаас авч нэгтгэн, аймгийн Засаг даргын Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, www.new.unelgee.gov.mn сайтад шивж баталгаажуулахад бэлэн болгов. Сум, байгууллагуудад ажилласан мөрөөр аймгийн төвийн 31 албан байгууллага, 5 өрхийн эрүүл мэндийн төв, 15 цэцэрлэг, 7 сургуульд ажил сайжруулах талаар хугацаатай үүрэг даалгавар өгч зөвлөмж хүргүүлэв. Зөвлөмжийн мөрөөр 21 албан байгууллага, 11 цэцэрлэг ажлын төлөвлөгөө гаргаж, төлөвлөгөөний хэрэгжилтийн тайлан ирүүлсэн болно.

2017 оны 12 дугаар сарын байдлаар Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг 3, Засгийн газрын 47 тогтоол, 15 хуралдааны тэмдэглэл, албан даалгавар 1, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 10, Тэргүүлэгчдийн 117 тогтоол, 2 хуралдааны тэмдэглэл хүлээн авч аймгийн удирдлагуудад танилцуулан, холбогдох хэлтэс, сум, байгууллагуудад олшруулан хүргүүлж, хэрэгжилтийн явцад хяналт тавьж ажиллав.

Долоо: Сумдын мэдээлэл:

Жаргалант сум: Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2017 оны ээлжит 4 дүгээр хуралдаанаар сумын Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Эдийн засаг нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтийг хэлэлцэн дүгнэж, эдийн засаг нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг баталлаа.

Сумын Засаг даргын 2017 оны А/259 дүгээр захирамжаар Мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх аян зохион байгуулах ажлын хэсэг байгуулагдан үйл ажиллагааны төлөвлөгөө гаргав. Тус ажлын хүрээнд аймгийн Цагдаагийн газартай

хамтран “Холболт” нэгдсэн арга хэмжээ зохион байгуулж мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх урьдчилан сэргийлэхэд олон нийтийг татан оролцуулах иргэдэд мэдээлэл хүргэх, төв суурин газрын хүнсний зах, махны үйлдвэрлэл үйлчилгээ эрхэлж буй мал мах бэлтгэж буй цэгт махны гарал үүсэлд хяналт тавих, худалдаалагдаж буй малын им тамга, гарал үүслийг шалгах зэргээр хяналт шалгалтыг тогтмол хийж ажиллаа.

Аймгийн Засаг даргын захирамжийн хэрэгжилтийг ханган сумын Засаг даргын захирамжаар томилогдсон ажлын хэсэг мал, хөдөө аж ахуйн тэжээвэр амьтдын тооллогын ажлыг зохион байгууллаа. Сумын нийт дүнгээр 113133 толгой мал тоологдсноос тэмээ 363, адуу 6052, үхэр 9842, хонь 38231, ямаа 58644 толгой мал байна.

Хоггүй Ховд хөтөлбөрийн хүрээнд хог хаягдлын төвлөрсөн цэгийн тархалтын хэмжээг бууруулах зорилгоор 600 метр газарт торон хашаа, 6 метрийн урттай хаалгыг орон нутгийн Хогийн сангийн 26 сая төгрөгөөр хийж гүйцэтгэв. Сумын 12 багийн нутаг дэвсгэрт ил задгай хог хаягдал хаях, бохир ус асгах явдлыг таслан зогсоох ажлын хэсгийг байгуулж нийт 6 багийн 72 гудамжинд нийтийн эзэмшлийн гудамж зам талбайд бохир ус асгасан 56 айл өрхөд улсын байцаагчийн мэдэгдэх хуудас өгч зөрчлийг арилгуулав.

Буянт сум: Тайлант сард иргэдээс бичгээр 67 өргөдөл хүлээн авч хуулийн хугацаанд бүрэн шийдвэрлэсэн ба иргэний бүртгэл мэдээллийн үйлчилгээг нийт 322 иргэнд үзүүллээ. Байгууллагын ажилтнуудын 2017 оны үр дүнгийн гэрээг дүгнэж, 2017 оны жилийн ажлын төлөвлөгөөний хэрэгжилтийг хэлэлцэв. Соёл урлагийн үйлчилгээгээг 1500 иргэдэд үзүүлж, номын сангаар давхардсан тоогоор 51 уншигч 150 ширхэг номоор үйлчлүүлсэн.

Сумын Эрүүл мэндийн төвөөр 595 иргэн үйлчлүүлж, үүнээс урьдчилсан сэргийлэх үзлэгт 146 иргэн хамрагдаж, амбулаториор 202, гэрийн идэвхитэй эргэлтээр 30, идэвхитэй хяналтаар 41 удаа явж үйлчилсэн. Нийт 14 өвчтөн хэвтэн эмчлүүлж, 40 удаа алсын дуудлагад явж эрүүл мэндийн тусламж үйлчилгээг шуурхай хүргэж ажиллав. Жирэмсний хяналтанд шинээр 12 эхийг, 3 сартай хүүхдүүдийг 100% хяналтанд авч, зохих шинжилгээнд хамруулан байнгын хяналттай ажиллаж байна. Товлолын дагуу хөдөөгийн багуудын 31 хүүхдийг дархлаажуулалтад хамруулав.

Янзага цэцэрлэг нь 100 хүүхэд хүлээн авах чадалтайгаас 2017-2018 оны хичээлийн жилд 4 бүлгийн 141 хүүхэд хүлээн авч үйл ажиллагаагаа амжилттай явуулж байна. “Авъяас” хөтөлбөрийн хүрээнд хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх, тэдний

авъяас чадварыг нээн илрүүлэх зорилгоор 5 төрлийн дугуйлан хичээллүүлж цэцэрлэгийн хүүхдүүдийн 91 хувь хамрагдаж байна. “Номын гэгээ” хөтөлбөрийн хүрээнд “Үлгэрийн баатрууд амилсан нь”, “Ном бүтээх” уралдааныг багш ажилчдынхаа дунд амжилттай зохион байгууллаа. Хүүхдийг эрүүл чанартай хоол хүнсээр хангахад анхаарч бүтээгдэхүүн нийлүүлэх тендерт шалгарсан компани болох “Буянтын цуурай”, “Хатан түнхэл”, “Үр жимс” хоршооноос чацаргана, мах, гурил, гурилан бүтээгдэхүүн зэргийг ариун цэвэр мэргэжлийн хяналтын байгууллагын зөвшөөрлөөр нийлүүлж байна.

Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын ээлжит хуралдаанаар 2018 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөг батлуулж, 5 газрыг улсын тусгай хамгаалалтанд авахаар шийдвэрлэв. Мөн сумын төвийн айлуудын хашааг бүрэн хаягжуулж, хаягын давхардлыг арилгав.

Сумын хэмжээний төл малд үзлэг шинжилгээг нийт 49287 төл малд үзлэг тандалт хийж багийн дарга, мал эмнэлэгийн үржлийн нэгжийн эмч нар өрх бүрээр нарийвчилсан судалгааг гаргав.

Сумын Хэсгийн төлөөлөгч болон цагдаа хэв журам сахиулахаар өдөр бүр шөнийн эргүүлээр ажиллаж, ахуйн дуудлагад 1 удаа, биеэ авч явах чадваргүй согтолттой 1 иргэнийг түр саатуулан ар гэр, асран хамгаалагчид нь хүлээлгэн өгч ажиллаа. Эргүүлийн үүрэг гүйцэтгэх хугацаанд архи, согтууруулах ундаагаар үйлчилдэг хүнсний дэлгүүрүүдэд хяналт шалгалт хийж ажиллав.

Манхан сум: Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар сумын Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2017 оны хэрэгжилтийн биелэлт, 2017 онд сумын нийгэм эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт, 2017 оны хүлээгдэж буй төсвийн гүйцэтгэлийг хэлэлцүүлж дүгнүүлэн, сумын нийгэм эдийн засгийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, 2018 оны төсвийн төслийг батлуулав.

“Захиргааны ерөнхий хууль”, “Зөрчлийн тухай хууль”-ийг багийн болон төсөвт байгууллагын дарга, эрхлэгч нарт сурталчилж “Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн бүх шатны хэрэгжилтийг тайлагнаж холбогдох газарт хүргүүлэв.

Дэлхийн байгаль хамгаалах сангаас цаасан хогийг багасгах, цаасны үнэ цэнийг мэдүүлэх, цаасны хэрэглээг багасгах зорилгоор “Цаасан хог хаягдал” сарын аян өрнүүлэн ажиллаж байна.

Аймгийн Боловсрол, соёл урлагийн газрын ажлын хэсэг байгууллагын үйл ажиллагаанд хяналт хийж зөвлөн туслах, аргагүйн зөвлөгөө өгч ажилласан ба багийн үнэлгээгээр 78 оноо авч 88,6 хувьтай шалгагдав.

Сумын Эрүүл мэндийн төв 26 орон тоотойгоор иргэдэд эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлж, урьдчилан сэргийлэх үзлэгт 127 хүн хамруулж 49 өвчтөн хэвтэн эмчлүүлэв Товлолын дархлаажуулалтанд 2 сартайгаас 2 нас хүртэлх 46 хүүхэд хамруулсан ба 2 эх эсэн мэнд амаржуулж, түргэн тусламжийн 9 дуудлагад үйлчлэв. 0-5 насны хүүхдийг сар бүр жигнэж, хүүхдийн өсөлт бойжилтонд хяналт тавин ажиллаж байна. Хэвтэн эмчлүүлж буй үйлчлүүлэгчдэд стандартын дагуу 210 нэр төрлийн эмээр үйлчлэв.

Сумын хэмжээнд туурайтан амьтны тандалт судалгаа, мониторинг хийж ан амьтдын өвөлжилтийн байдлын дүгнэлт гаргаж Дэлхийн байгаль хамгаалах санд хүргүүллээ.

Цэцэг сум: Аймгийн Засаг даргын Тамгын газраас санаачлан зохион байгуулж буй “Малчиддаа тусалъя” сайн санааны аяны хүрээнд 5 багийн иргэдийн сэтгэлийн хандиваар 875.0 мянган төгрөг цугалж, тус мөнгийг сумын Улаан загалмайн нэрийн дансанд төвлөрүүлэв.

Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн ээлжит хурлаар сумын Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2017 оны хэрэгжилтийг хэлэлцүүлэн дүгнэж, сумын эдийн засгийг хөгжүүлэх 2018 оны үндсэн чиглэлийг батлуулав.

Эрдэнэбүрэн сум: Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын ээлжит 7 дугаар хуралдаан 2017оны 12 дугаар сарын 01-ний өдөр хуралдаж, сумын эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт, сумын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлийн 2017 оны ажлын тайлан, сумын 2015-2025 оны хөгжлийн стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийн явцыг хэлэлцэн дүгнэв.

Мөн ээлжит 8 дугаар хуралдаан 2017 оны 12 сарын 15-ны өдөр хуралдаж, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2017 оны үйл ажиллагааны тайлан, цаашдын зорилтын тухай, сумын Засаг даргын 2017-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2017 оны хэрэгжилтийн дүн, сумын 2016 оны төсвийн гүйцэтгэл, 2017 оны төсвийн хүлээгдэж байгаа гүйцэтгэл, 2018 оны төсвийн төслийн тухай, сумын газар зохион байгуулалтын 2017 оны төлөвлөгөөний биелэлт, 2018 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний тухай, хэлэлцэн харилцан санал солилцов.

Сумын Засаг даргын захирамжаар 2017 оны жилийн эцсийн мал тооллогын ажлыг зохион байгуулах ажлын хэсэг томилогдон 2017 оны 12 сарын 07-18-ны өдрүүдэд ажиллаа. Сумын дүнгээр 212223 толгой мал тоолуулсан нь өмнөх оноос 4606 толгой мал буюу 2,2 хувиар буурсан байна. 2017 онд 17 малчин шинээр 1000 давсан мал тоолуулж, сумын мянгат малчдын тоо 59 боллоо.

Мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх вакциныг 34171 хурга, 31616 ишиг, сумын хэмжээнд нийт 65787 толгой төл малд хийв. "Санхүүгийн боловсрол олгох 2 сарын аян"-ы хүрээнд сумын насан туршийн боловсрол төвөөс баг, байгууллагуудын дунд "Дэвжээ" тэмцээн, сурагчдын дунд эсээ бичлэгийн уралдаан, гар зургийн уралдааны материалаар үзэсгэлэн гаргаж иргэдэд сонирхууллаа.

Төрийн албан хаагчид, иргэдийн дунд "Хувь хүний санхүүгийн төлөвлөлт", "Өрхийн төсөв", "Хадгаламж ба хуримтлал" сэдэвтэй сургалтууд зохион байгуулж нийт 107 хүн хамрагдав.

"Бидний цөөхөн Монголчууд" төслийн баг 2017 оны 12 сарын 11, 12-ны өдрүүдэд суманд ажиллаж өөлдүүдийн сар шинийн "Дээл мөргөх ёс", Галдан хааны Харлаг сүлд цэнгүүлэх арга хэмжээ, өөлдийн урлаг соёлын болон түүх дурсгалт газрын зураг авч телевиз болон киноны бичлэг хийж, баг, байгууллагын болон малчдын ажил, амьдралтай танилцаж ярилцлага авч, бичлэг хийлээ. Энэхүү телевизийн бичлэг нь сумын ёс заншил, өв соёл, уламжлалын талаар ирээдүй хойч үедээ үлдээх түүх бүтээж буй томоохон арга хэмжээ боллоо.

Монгол улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, Засгийн газрын зарлиг, тогтоол шийдвэрийн 101, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн 71, сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 138, сумын эдийн засаг, 2017 онд нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн 85, аймаг, сумын Засаг даргын хооронд байгуулсан Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх тухай гэрээний 64 заалтуудын хэрэгжилтийг гаргаж аймгийн ЗДТГ-т хүргүүллээ.

2017 оны 12 дугаар сарын 01-ний өдөр сумын Эрүүл мэндийн төвөөс "ДОХ-той тэмцэх өдөр"-ийг тохиолдуулан сумын төсөвт байгууллагуудын албан хаагчид болон ард иргэд олон нийт болох 120 хүнд таних тэмдэг улаан тууз нааж, сурталчилгааны гарын авлага материал өгөв.

Сумын удирдах ажилтны шуурхай зөвлөгөөнийг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын ажлын алба, Засаг даргын Тамгын газраас зохион байгуулж

цаг үеийн мэдээ мэдээлэл хийж, сумын удирдлагуудад 2018 онд хийх ажлын үүрэг чиглэл өгөв.

Мөнххайрхан сум: Сумын Засаг даргын зөвлөлийн хурлыг 2 удаа зохион байгуулж, төсөв хөрөнгө зарцуулах тухай, Монгол улсын Ерөнхий сайдын 01 дүгээр албан даалгаврын хэрэгжилтийн явцын тухай мэдээллийг хэлэлцэж, холбогдох газарт хүргүүлэв.

Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 5 дугаар хуралдаан 2017 оны 12 дугаар сарын 14-ны өдөр хуралдуулж, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Борт багийн нөхөн сонгуулиар томилогдсон Төлөөлөгчийн бүрэн эрхийг хүлээн зөвшөөрч, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тайлан илтгэл, сумын Засаг даргын үйл ажиллагааны 2016-2020 оны хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, эдийн засаг, нийгмийн 2017 оны үндсэн чиглэлийн хэрэгжилт, 2018 оны үндсэн чиглэлийн тухай илтгэл, 2016 оны төсвийн гүйцэтгэл, 2017 оны төсвийн тодотгол, 2018 оны төсвийн төслийн тухай илтгэл, малчдын бүлгийн хүсэлт, зохистой ан агнуурын тухай, газар зохион байгуулалтын төлөвлөгөөний 2017 оны хэрэгжилт, 2018 оны төлөвлөгөөний тухай асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэв.

Хуралдаанаас сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурал “Иргэдийн оролцоотой хяналт шалгалтыг эрчимжүүлэх жил”, сумын 2018 оны эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийг “Бүтээн байгуулалт-Аялал жуулчлалыг хөгжүүлэх жил” болгон зарлаж, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын үйл ажиллагаа, Засаг даргын хөтөлбөр, үндсэн чиглэлийн хэрэгжилтэнд “Хангалттай” үнэлгээ өгч, сумын төсөв, газар зохион байгуулалтын төлөвлөгөөг батлан, малчдын бүлэгт газар нутгийг хариуцуулан хамгаалуулах шийдвэр гаргав.

“Малчиддаа туслая” 3 сарын сайн санааны аян зохион байгуулах ажлын удирдамж, ард иргэд, аж ахуй нэгж байгууллагуудыг уриалсан уриалга гарган зохион байгуулалтын асуудлыг сумын Засаг даргын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэлээ. Мөн сумын төсөвт албан байгууллагууд “Нэг байгууллага-нэг өрх” хөдөлгөөн өрнүүлэн 5 өрх айл сонгон тусламжийн арга хэмжээг хэрэгжүүллээ.

Сумын Засаг даргын захирамжаар мал, хүн амын тооллогын комисс, хяналтын ажлын хэсгийг томилон жилийн эцсийн тоо, цэргийн шинэчилсэн бүртгэл, төрийн албан хаагчийн хүний нөөцийн программд мэдээлэл оруулах ажлуудыг хийж гүйцэтгэв. Мөн Ерөнхий сайдын 2017 оны 01 албан даалгаврын биелэлт, үндэсний

хөтөлбөрийн тайлан, тогтоол шийдвэрийн биелэлт, 2018 оны нэгдсэн арга хэмжээний төлөвлөгөөнд тусгах саналыг аймгийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэв.

Боловсрол соёл, шинжлэх ухааны сайдын багцаас Хүүхдийн цэцэрлэгийн гадна тоглоомын талбай байгуулах 10,0 сая төгрөгийн өртөгтэй төслийг уламжилж, шийдвэрлүүлэн 3ш тоглоом, талбайн хашилт хамгаалалтын ажлыг гүйцэтгүүлж, ашиглалтанд хүлээн авав.

Ойн хандивын хөрөнгөнөөс хийх ажлын талаар сумын Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн Иргэний танхимын тохижилтонд 2,7 сая төгрөг зарцуулж, Засаг даргын Тамгын газрын иргэний танхимд 5 ширээ, 11 сандал нийлүүлж, танхимын хаягийг хийлгэж, тохижууллаа.

Сумын орон нутгийн төсөвт байгууллагууд болон тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын төсөв, санхүүгийн үйл ажиллагаа хэвийн төсөвт байгууллагууд сарын ажлын болон шилэн дансны мэдээллийг хугацаанд нь гаргаж холбогдох газарт хүргүүлэв. Орон нутгийн төсөвт санхүүгийн дэмжлэгээр 55106.3 мян/төг, орон нутгаас төсөвт төвлөрөх орлогоор 1048.1 мян/төгрөгийн санхүүжилт авч, нийт 56154.4 мян/төг үүнээс сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хуралд 3900.7 мян/төг, сумын Засаг даргын Тамгын газарт 51739.7 мян/төгрөгийг тус тус санхүүжилтэнд олгов.

Орон нутгийн хөгжлийн санд жилийн дүнгээр 51809.1 мян/төг батлагдсанаас МЭУСАХ-ний санхүүжилтэнд 118526.0 мян/төгрөгийг 2 мал эмнэлэгт хувиарлан олгов. Орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрээр хэрэгжих төсөл хөтөлбөр арга хэмжээнүүдийг батлагдсан төсвийн хүрээнд тендер шалгаруулалт, шууд худалдан авалт хэлбэрээр хуулийн дагуу хэрэгжүүлж дуусгав.

Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын санхүүжилтээр нийт 117327.8 мян/төгрөгөөс ерөнхий боловсролын 12 жилийн дунд сургууль, Хүүхдийн цэцэрлэг, Соёлын төв, Эрүүл мэндийн төв төсөвт байгууллагуудад хуваарийн дагуу санхүүжилт олгож зарлагын гүйлгээнүүдийг хийв. Орон нутагт тусгай зориулалтын шилжүүлгийн 9 байгууллагын 16 данснаас 1838 ширхэг төлбөрийн хүсэлтээр 1840684152 төгрөгийн гүйлгээ шивэв.

Энэ оны жилийн эцсээр урьдчилсан байдлаар 586 өрхөд, 2204 хүн ам тоологдож, 448 малтай өрхөд, 140130 толгой мал тоологдож, урьд оноос мал 8759 толгойгоор өслөө.

Сумын Эрүүл мэндийн төвд 25 иргэн хэвтэн эмчлүүлж, эмийн бус эмчилгээгээр 63 хүнд үйлчлэв. 0-2 насны 27 хүүхдийг товлолын дархлаажуулалтанд хамруулав. “Элэг бүтэн-Монгол” үндэсний хөтөлбөрийн хүрээнд элэгний в,с вирусын шинжилгээнд нийт 282 хүн хамрагдаж хамралт 60 хувьтай байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн зөвлөх Ш.Адьяагийн санаачлага, дэмжлэгтэйгээр сумын Эрүүл мэндийн төвд нийт 54 сая төгрөгийн санхүүжилтээр Пургон автомашин, ЭХО аппарат, өвчтөний 10 ширхэг ор хүлээн авав.

Сумын Соёлын төвийн Номын санчийн санаачлагаар 14 хоногийн “Номтой нөхөрлөө” аян өрнүүлж, аяны хүрээнд 1-5 дугаар ангийн сурагчдын дунд “Тэргүүний уншигч” шалгаруулах уралдаан, 6-12 дугаар ангийн сурагчдын дунд богино өгүүллэгийн уралдаан тус тус зохион байгуулж, уралдаанд тэргүүн байр эзэлсэн сурагчдыг шагнаж урамшуулав.

Цэцэрлэгийн багш, ажилчид хүүхдүүийн авьяас чадвар сэтгэхүйг хөгжүүлэх чиглэлд анхаарч төрөл бүрийн дугуйлангуудыг тогтмол хичээллүүлж байна. Мөн хүүхдийг шүд, хоолойн өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор ам хоолой зайлах, цайны дараа амны хуурай угаалга хийх, хоолны өмнө гараа угаах дараа шүд угаах үйл ажиллагааг хийлгэж хэвшлээ.

Хөдөлмөр халамж үйлчилгээний сангаас 5600000 төгрөгөөр сумын ажилгүй 20 иргэдийг түр ажлын байраар ханган 2017 оны 12 дугаар сарын 01-10 өдрүүдэд сумын төвийн хогийн цэгийн хашааг сэргээх, хог хаягдлыг цэвэрлэж, хогийн цэг доторхи зам засаж сайжруулах, мөн сумын урд улаан, хойд хар уулын эзэнгүй хур хог хаягдал, Сэнхэрийн голын ай сав дагуух хогийг цэвэрлэн нийт 24 тн хог хаягдлыг цэвэрлэсэн.

Сумын хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах салбар нийгэмлэгээс төлөвлөгөөт хяналт шалгалтыг зохион байгуулж, дэлгүүр үйлчилгээний газруудад стандарт шаардлагын дагуу 5 үзүүлэлтээр хяналт шалгалт хийж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулж, Хүнсний тухай хууль, Хүнсний аюулгүй байдлын тухай хуулиудаар сургалт зохион байгуулж, гарын авлага, сэрэмжлүүлэг, зөвлөмж өгч ажиллав.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР